

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/233-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn www.open.audit.mn Сүхбаатар сум 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------	---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2 Материаллаг байдал.....	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	20
5.1 Албан шаардлага.....	20
5.2 Зөвлөмж.....	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
ГХУСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
МУЕА	Монгол улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар
ШШГХ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

МАНДАЛ СУМ ДАХЬ ШҮҮХИЙН
ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ХЭЛТЭС-413
ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ
ХОРИХ АНГИЙН ДАРГА, ДЭД
ХУРАНДАА А.БУЯНБААТАР ТАНАА

2023.02.17 № САА-2023/233-НА-СТА-ТМЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн 2,341,504.7 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 100.0 хувьтай тайлагнагдсан байна.

Өөрийн дотоод үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар 212,689.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Аудитын гол асуудал

ШШГЕГ-ын 413 дугаар хаалттай хорих ангийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 60.8 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх НДШ-ийн, 12.9 хувийг нормативт, 10.5 хувийг тогтмол, 5.2 хувийг

хангамж бараа материалын, 4.9 хувийг эд хогшил урсгал засварын зардал тус тус эзэлж байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.ЭНХТУЯА



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	282,147,022.19	459,231,078.69
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	16,941,967.97	24,204,817.88
31200	Банканд байгаа бэлэн мөнгө	16,941,967.97	24,204,817.88
31210	Төгрөг	16,941,967.97	24,204,817.88
31211	Төрийн сангийн харилцах	16,941,967.97	24,204,817.88
33	АВЛАГА	7,000,000.00	10,000,000.00
33500	Бусад авлага	7,000,000.00	10,000,000.00
33510	Байгууллагаас авах авлага	7,000,000.00	10,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	258,205,054.22	425,026,260.81
35100	Түүхий эд материал	42,603,516.13	48,859,282.69
35110	Тусгай зориулалттай материал	40,242,060.20	45,348,778.39
35130	Эм боох материал	2,361,455.93	3,510,504.30
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	12,945,504.44	15,623,085.37
35300	Бэлэн бүтээгдэхүүн	84,869,731.66	120,572,559.40
35400	Хангамжийн материал	78,212,501.99	122,071,333.35
35410	Бичиг хэргийн материал	1,360,907.52	1,643,367.52
35420	Аж ахуйн материал	32,319,262.64	58,209,771.31
35430	Сэлбэг хэрэгсэл	3,985,000.00	6,585,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,537,087.20	2,443,135.10
35450	Барилгын засварын материал	14,316,156.66	15,714,400.66
35460	Хүнсний материал	19,354,865.60	21,485,763.95
35470	Бусад хангамжийн материал	5,339,222.37	15,989,894.81
35600	Мал амьтад	39,573,800.00	117,900,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	11,268,543,506.46	11,332,348,564.73
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	11,268,543,506.46	11,332,348,564.73
39200	Биет хөрөнгө	2,866,281,506.46	2,928,482,064.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,807,434,980.71	2,856,302,084.76
39202	Хуримтлагдсан элэгдэл	-341,613,336.02	-442,951,885.32
39203	Авто-тээврийн хэрэгсэл	365,253,875.00	337,203,875.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-260,192,207.63	-255,620,540.94
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	573,219,626.17	690,424,273.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-386,329,160.81	-410,844,575.87
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,020,247.29	65,186,329.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-36,036,648.37	-36,142,975.32
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	28,170,620.00	28,170,620.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	17,252,000.00	17,252,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-7,193,099.88	-8,271,549.84
39216	Дуусаагүй барилга, байгууламж	54,294,610.00	87,774,410.09
39300	Биет бус хөрөнгө	8,402,262,000.00	8,403,866,500.00
39301	Программ хангамж	6,417,692.31	1,604,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-6,417,692.31	0.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,402,262,000.00	8,402,262,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	11,550,690,528.65	11,791,579,643.42
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	73,516,182.39	63,166,913.42
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	73,516,182.39	63,166,913.42
41300	Өглөг	73,516,182.39	63,166,913.42
41360	Бусад өглөг	73,516,182.39	63,166,913.42

41361	Байгууллагад төлөх өглөг	59,553,054.50	43,862,527.37
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	13,963,127.89	19,304,386.05
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	11,477,174,346.26	11,728,412,730.00
51	Засгийн газрын хувь оролцоо	11,477,174,346.26	11,728,412,730.00
51100	Засгийн газрын оруулсан капитал	8,727,358,630.01	8,727,358,630.01
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	8,727,358,630.01	8,727,358,630.01
51200	Хуримтлагдсан үр дүн	484,568,852.65	742,234,111.73
51210	Өмнөх үеийн үр дүн	617,925,353.30	490,995,727.99
51220	Тайлант үеийн үр дүн	-133,356,500.65	251,238,383.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,265,246,863.60	2,258,819,988.26
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	11,550,690,528.65	11,791,579,643.42

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,406,913,026.27	2,966,938,513.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	373,895,088.27	751,696,631.47
120	Нийтлэг татварын бус орлого	373,895,088.27	732,324,131.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	274,733,710.27	534,936,117.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	51,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	264,841,970.41	301,435,983.14
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,891,739.86	182,500,134.50
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	34,398,237.00	109,449,919.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	64,763,141.00	87,938,094.83
122	Тусламжийн орлого	0.00	19,372,500.00
122001	Хандив тусламж /дотоод/	0.00	19,372,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,033,017,938.00	2,215,241,882.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,003,640,700.00	2,129,872,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,003,640,700.00	2,129,872,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	29,377,238.00	85,369,482.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,328,238.00	10,415,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,049,000.00	65,953,982.50
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,540,269,526.92	2,715,700,130.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,540,269,526.92	2,715,700,130.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,446,284,738.61	2,644,757,483.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,363,403,158.73	1,387,329,388.26
210101	Үндсэн цалин	896,951,695.25	915,950,356.28
210102	Нэмэгдэл	466,451,463.48	457,187,861.68
210104	Урамшуулал	0.00	14,191,170.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,144,101.19	28,109,300.00
210201	Тэтгэврийн даатгал	1,092,958.42	1,264,940.25
210202	Тэтгэмжийн даатгал	90,266.24	148,816.50

210203	ҮОМШӨ-ний даатгал	72,213.01	119,053.20
210204	Ажилгүйдлийн даатгал	18,053.23	29,763.31
210205	Эрүүл мэндийн даатгал	26,870,610.29	26,546,726.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	209,377,724.03	240,424,979.77
210301	Гэрэл, цахилгаан	110,515,401.37	117,216,410.15
210302	Түлш, халаалт	80,720,022.66	119,484,849.62
210303	Цэвэр, бохир ус	18,142,300.00	3,723,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	151,267,256.97	250,699,723.84
210401	Бичиг хэрэг	7,614,874.51	9,795,390.00
210402	Тээвэр, шатахуун	28,832,379.60	59,859,295.46
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,740,109.99	3,612,593.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	496,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,903,650.00	31,974,860.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	93,916,942.87	137,606,561.61
210408	Бараа материал ақталсны зардал	4,763,300.00	7,401,022.90
2105	Нормативт зардал	336,478,989.31	369,506,328.07
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,472,419.10	15,139,251.63
210502	Хоол, хүнс	289,495,044.71	315,064,955.94
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,511,525.50	39,302,120.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	52,585,781.73	81,250,973.50
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,137,600.00	5,430,558.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	156,500.00	0.00
210604	Урсгал засвар	41,291,681.73	75,820,415.50
2107	Томилот, зочны зардал	731,800.00	445,400.00
210702	Дотоод албан томилот	731,800.00	445,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,636,190.00	32,496,519.99
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	13,319,690.00	26,121,523.99
210804	Тээврийн хэрэгслийн татвар	936,900.00	576,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	533,000.00	495,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,108,000.00	523,700.00
210807	Газрын төлбөр	4,738,600.00	4,779,636.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	283,659,736.65	254,494,869.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,780,740.65	21,919,408.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,203,500.00	0.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	235,675,496.00	232,575,460.82
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	93,984,788.31	70,942,647.02
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	23,167,200.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	23,167,200.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	10,567,498.40	14,886,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,567,498.40	14,886,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	235,210.00	1,056,647.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	235,210.00	1,056,647.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	60,014,879.91	55,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	60,014,879.91	55,000,000.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	-133,356,500.65	251,238,383.74
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-133,356,500.65	251,238,383.74

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,501,850,220.04	2,648,200,982.89
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	383,899,347.04	432,959,100.39
120	Нийтлэг татварын бус орлого	383,899,347.04	432,959,100.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	367,275,004.51	423,558,908.64
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	51,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	367,275,004.51	372,558,908.64
120009	Бусад орлого	16,624,342.53	9,400,191.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,117,950,873.00	2,215,241,882.50
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,003,640,700.00	2,129,872,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,003,640,700.00	2,129,872,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	114,310,173.00	85,369,482.50
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	0.00	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	109,261,173.00	14,415,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	5,049,000.00	65,953,982.50
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,445,192,468.60	2,582,614,332.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,445,192,468.60	2,582,614,332.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,326,400,098.19	2,487,420,499.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,379,731,722.43	1,396,075,900.00
210101	Үндсэн цалин	903,045,884.64	837,798,972.78
210102	Нэмэгдэл	476,685,837.79	544,567,362.37
210104	Урамшуулал	0.00	13,709,564.85
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,339,880.02	28,109,300.00
210201	Тэтгэврийн даатгал	1,191,281.92	0.00
210202	Тэтгэмжийн даатгал	105,191.38	0.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	71,033.11	0.00
210204	Ажилгүйдлийн даатгал	17,758.25	0.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,954,615.36	28,109,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	211,733,500.00	247,079,600.00
210301	Гэрэл, цахилгаан	111,892,643.74	122,964,982.48
210302	Түлш, халаалт	81,698,556.26	120,390,897.52
210303	Цэвэр, бохир ус	18,142,300.00	3,723,720.00
2104	Хангамж, бараа материалын зардал	83,641,073.00	141,821,224.50
210401	Бичиг хэрэг	4,512,840.01	8,090,850.00
210402	Тээвэр, шатахуун	64,283,438.00	120,947,238.63
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,740,109.99	3,612,593.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	496,000.00	450,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	11,608,685.00	8,720,542.00
2105	Нормативт зардал	291,029,800.00	305,346,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	13,369,400.00	14,783,300.00
210502	Хоол, хүнс	277,660,400.00	290,562,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,263,801.73	94,335,658.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	20,118,501.73	6,293,400.00

210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,049,300.00	2,049,300.00
210604	Урсгал засвар	68,096,000.00	85,992,958.00
2107	Томилолт, зочны зардал	731,800.00	445,400.00
210702	Дотоод албан томилолт	731,800.00	445,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	133,052,611.01	170,743,467.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	125,736,111.01	164,730,607.34
210804	Тээврийн хэрэгслийн татвар	936,900.00	576,660.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	533,000.00	447,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,108,000.00	523,700.00
210807	Газрын төлбөр	4,738,600.00	4,464,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	107,875,910.00	103,463,950.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	106,668,110.00	100,512,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,207,800.00	2,951,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	118,792,370.41	95,193,833.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	23,167,200.00	0.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	23,167,200.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	9,895,200.00	11,936,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,895,200.00	11,936,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	235,210.00	1,056,647.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	235,210.00	1,056,647.02
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	85,494,760.41	82,201,186.12
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	85,494,760.41	82,201,186.12
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	56,657,751.44	65,586,649.91
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	54,368,498.27	58,323,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,368,498.27	58,323,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,368,498.27	58,323,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	54,368,498.27	58,323,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-54,368,498.27	-58,323,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,289,253.17	7,262,849.91
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	14,652,714.80	16,941,967.97
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	16,941,967.97	24,204,817.88

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,265,246,863.60	617,925,353.30	11,610,530,846.91
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,727,358,630.01	2,265,246,863.60	617,925,353.30	11,610,530,846.91
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-133,356,500.65	-133,356,500.65
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,265,246,863.60	484,568,852.65	11,477,174,346.26
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	8,727,358,630.01	2,265,246,863.60	484,568,852.65	11,477,174,346.26
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	6,426,875.34	6,426,875.34
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,727,358,630.01	2,265,246,863.60	490,995,727.99	11,483,601,221.60
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-6,426,875.34	0.00	-6,426,875.34
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	251,238,383.74	251,238,383.74
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	8,727,358,630.01	2,258,819,988.26	742,234,111.73	11,728,412,730.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү /хэтрэлт, хэмнэлт/	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,341,504,700.00	2,341,504,660.00	-40.00	100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,341,504,700.00	2,341,504,660.00	-40.00	100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,339,947,300.00	2,339,947,260.00	-40.00	100.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,396,075,900.00	1,396,075,900.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	876,962,300.00	837,798,972.78	-39,163,327.22	95.53
210102	Нэмэгдэл	514,169,600.00	544,567,362.37	30,397,762.37	105.91
210104	Урамшуулал	4,944,000.00	13,709,564.85	8,765,564.85	277.30
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28,109,300.00	28,109,300.00	0.00	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	28,109,300.00	28,109,300.00	0.00	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	247,079,600.00	247,079,600.00	0.00	100.00
210301	Гэрэл, цахилгаан	121,522,900.00	122,964,982.48	1,442,082.48	101.19

210302	Түлш, халаалт	111,623,200.00	120,390,897.52	8,767,697.52	107.85
210303	Цэвэр, бохир ус	13,933,500.00	3,723,720.00	-10,209,780.00	26.72
2104	Хангамж, бараа материалын зардал	122,726,000.00	122,726,000.00	0.00	100.00
210401	Бичиг хэрэг	2,911,700.00	8,090,850.00	5,179,150.00	277.87
210402	Тээвэр, шатахуун	109,696,700.00	102,790,414.13	-6,906,285.87	93.70
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,891,200.00	3,612,593.87	1,721,393.87	191.02
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	349,900.00	450,000.00	100,100.00	128.61
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,876,500.00	7,782,142.00	-94,358.00	98.80
2105	Нормативт зардал	302,363,200.00	302,363,200.00	0.00	100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	11,800,500.00	11,800,500.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	290,562,700.00	290,562,700.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	112,356,600.00	112,356,600.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	59,878,800.00	59,878,800.00	0.00	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,049,300.00	2,049,300.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	50,428,500.00	50,428,500.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	445,400.00	445,400.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	445,400.00	445,400.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,866,700.00	39,866,660.00	-40.00	100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,853,800.00	33,853,800.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	576,700.00	576,660.00	-40.00	99.99
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	447,900.00	447,900.00	0.00	100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	523,700.00	523,700.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	4,464,600.00	4,464,600.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	90,924,600.00	90,924,600.00	0.00	100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	89,973,000.00	89,973,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	951,600.00	951,600.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,557,400.00	1,557,400.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,557,400.00	1,557,400.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,557,400.00	1,557,400.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,341,504,700.00	2,342,561,267.02	1,056,567.02	100.05
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,129,872,400.00	2,129,872,360.00	-40.00	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,129,872,400.00	2,129,872,360.00	-40.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	211,632,300.00	212,688,907.02	1,056,607.02	100.50
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	51,000,000.00	51,000,000.00	0.00	100.00
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	160,632,300.00	161,688,907.02	1,056,607.02	100.66

6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	207	207	0	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	103	103	0	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	101	101	0	100.00
620003	Үйлчлэх ажилтан	1	1	0	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	103	103	0	100.00
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	103	103	0	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	85,369,452.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	85,369,452.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	82,369,452.50
2104	Хангамж, бараа материалын зардал	19,095,224.50
210402	Тээвэр, шатахуун	18,156,824.50
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	938,400.00
2105	Нормативт зардал	2,982,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,982,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	39,564,458.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,00.00
210604	Урсгал засвар	35,564,458.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,549,250.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,549,250.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,177,750.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,177,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,000,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,000,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	85,369,482.50
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	85,369,482.5
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,415,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	65,953,982.50

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар нээлттэй, хаалттай хорих анги / Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих анги/ нь “Удирдах ажилтны манлайлал, алба хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлж, аюулгүй байдал, хууль ёсны эрх ашгийг хамгаалах, үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлж, шуурхай байдлыг хангах” гэсэн зорилт тавин ажилласан байна.

Байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд технологийн дэвшлийг нэвтрүүлэн, ашиглалтыг эрчимжүүлэх,
- Байгууллагын үйл ажиллагааг цахимжуулах ажлыг шат дараатай хэрэгжүүлэх,
- Шударга ёс, ил тод байдлыг хангаж, иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг шуурхай, хүндрэлгүй зохион байгуулах,
- Нийт бие бүрэлдэхүүнтэй цэрэгжилт, албаны бэлэн байдал, сахилга, хариуцлагыг дээшлүүлэх.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 2022 оны 04 дүгээр сарын 22, 6 дугаар сарын 03, 28, 12 дугаар сарын 23-нд орсон холбогдох өөрчлөлтүүд,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоосон гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн санхүүгийн үйл ажиллагаанд ШШГЕГ-ын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас тайлант онд хяналт шалгалт хийж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мандал сум дахь ШШГХ-413 дугаар хорих ангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг **аккруэл** сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

ШШГЕГ-ын даргын 2020 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн А/134 дүгээр тушаалаар ШШГЕГ болон түүний харьяа байгууллагын хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 240,889.1 мянган төгрөгөөр буюу 2.1 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	16,942.0	24,204.8	7,262.8
Авлага	7,000.0	10,000.0	3,000.0
Бараа материал	258,205.0	425,026.2	166,821.2
Үндсэн хөрөнгө	11,268,543.5	11,332,348.6	63,805.1
Нийт хөрөнгө	11,550,690.5	11,791,579.6	240,889.1
Өр төлбөр	73,516.2	63,166.9	-10,349.3

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	11,477,174.3	11,728,412.7	251,238.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	11,550,690.5	11,791,579.6	240,889.1

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 24,204.8 мянган төгрөг болж өмнөх оноос 7,262.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд хоригдлын нэрийн дансанд байршиж байгаа цалин, ар гэрээс шилжүүлсэн мөнгөний үлдэгдэл 19,304.4 мянган төгрөг, “Ахмадын сан” дансны үлдэгдэл 4,900.4 мянган төгрөг байгаатай холбоотой байна..

Авлагын дансны үлдэгдэл 10,000.0 мянган төгрөг болж 3,000.0 мянган төгрөгөөр өссөн нь нь БИММ ХХК-тай холбоотой 7,000.0 мянган төгрөгийн авлагын барагдуулж, Монголиан Грийн Фармер ХХК нь хүнсний ногоо худалдан авсан төлбөрөөс 10,000.0 мянган төгрөгийг дутуу төвлөрүүлснээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 425,026.2 мянган төгрөг болж 166,821.2 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээнээс шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 812,956.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан,
- ШШГЕГ-аас 87,938.1 мянган төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан,
- 563,308.4 мянган төгрөгийн материалыг дуусаагүй үйлдвэрлэлээс бэлэн бүтээгдэхүүн, мал амьтад, хүнсний материал зэрэг бараа материалын дансны ангилал хооронд шилжүүлсэн,
- 1,028,952.5 мянган төгрөгийн материалыг зарцуулсан,
- 261,028.7 мянган төгрөгийн материалыг бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэл, мал амьтад гэх мэт бараа материалын дансны ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан,
- 7,401.0 мянган төгрөгийн материалыг акталж, устгасан гэх мэт.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 12,486,180.1 мянган төгрөг болж 179,854.4 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил гүйлгээтэй холбоотой байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 58,323.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан,
- 19,372.5 мянган төгрөгийн өртөгтэй спорт заал хүлээж авсан,
- ШШГЕГ-аас 96,300.8 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 13,149.1 мянган төгрөгийн тавилга эд хогшил үнэ төлбөргүй шилжүүлэн авсан,
- Үндсэн хөрөнгийг дахин үнэлсний орлого 75,754.5 мянган төгрөг,
- 33,479.8 мянган төгрөгийн хөрөнгүүдийг дуусаагүй барилга байгууламжаар бүртгэсэн,
- Үлдэх өртөггүй 116,526.1 мянган төгрөгийн 35 ширхэг хөрөнгийг акталж устгасан гэх мэт.

Өр төлбөр дансны үлдэгдэл 63,166.9 мянган төгрөг болж, 10,349.3 мянган төгрөгөөр буурсан нь хоригдлын нэрийн дансанд байршиж байгаа цалин, ар гэрээс илгээсэн мөнгөний үлдэгдэл 5,341.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн, байгууллагад төлөх өглөг 15,690.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалсан байна.

Өр төлбөр дансанд 43,862.5 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг, 19,304.4 мянган төгрөгийн хувь хүмүүст төлөх өглөг бүртгэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 11,728,412.7 мянган төгрөг болж 251,238.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үйл ажиллагааны нийт үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,614,193.5 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 313,767.3 мянган төгрөг, нийт зарлагыг 2,927,960.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас дараах байдлаар өөрчлөн баталсан байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 93,027.2 мянган төгрөгөөр,
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,311.2 мянган төгрөгөөр,
- Байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 120,459.0 мянган төгрөгөөр,
- Хангамж, бараа материалын зардлыг 69,496.0 мянган төгрөгөөр,
- Нормативт зардлыг 288,604.4 мянган төгрөгөөр,
- Эд хогшил, урсгал засварын зардлыг 177,800.6 мянган төгрөгөөр,
- Томилолт, зочны зардлыг 5,628.0 мянган төгрөгөөр,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 25,916.5 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 54,195.2 мянган төгрөгөөр,
- Урсгал шилжүүлгийн зардлыг 43,902.6 мянган төгрөгөөр тус тус бууруулж, 2,037,195.4 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 304,309.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж /цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 11,647.2 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 73,679.6 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 53,230.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 24,302.8 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 80,907.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 46,716.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж баталсан нь голлон нөлөөлсөн/ төсвийн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,129,872.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 211,632.3 мянган

төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөн, гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,129,872.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоор 212,689.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,341,504.7 мянган төгрөг буюу 100.0 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

				/мянган төгрөгөөр/	
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагааны зардал	2,113,910,700.0	2,113,910,700.0	0.0	100.0
2	Туслах үйл ажиллагааны зардал	160,632,300.0	160,632,300.0	0.0	100.0
3	Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ	10,122,300.0	10,122,300.0	0.0	100.0
4	Шийдвэр гүйцэтгэлийн үйлчилгээ	4,282,000.0	4,282,000.0	0.0	100.0
5	Шүүхийн шийдвэрийн үйлдвэрлэлийн арга хэмжээ	51,000,000.0	51,000,000.0	0.0	100.0
6	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	1,557,400.0	1,557,400.0	0.0	100.0
	Нийт	2,341,504,700.0	2,341,504,700.0	0.0	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ШШГЕГ-аас 1 тэрбум модны үндэсний хөдөлгөөний хүрээнд хуваарилсан санхүүжилт 10,415.5 мянган төгрөг, ИТХ-ын ГХУСЗ-аас 4,000.0 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 65,954.0 мянган төгрөг, хандив тусламжийн 5,000.0 зэрэг нийт 85,369.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан,

төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн тээвэр, шатахууны зардал, хөрөнгийн ангилал, бүртгэл, анхан шатны баримт, төлбөрийн цахим баримт, төрийн байгууллагын мөнгөн касс, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих ангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/88 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,540,269.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу **25,402.7** сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор ШШГЕГ-ын даргын 2022 оны 02 дугаар “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай” албан даалгавар, Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газрын даргын 2022 оны 06/41 дугаар “Төсвийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 06/137 дугаар “Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” албан бичгийг хэрэгжүүлж, дараах арга хэмжээнүүдийг авсан байна. Үүнд:

- Дотоод үйлдвэрлэлээс алба хаагч, хоригдлын хүнсэнд нийт 84.4 тн төмс хүнсний ногоо, мал аж ахуйгаас 4.2 тн мах махан бүтээгдэхүүн 2.1 тн сүү, сүүн бүтээгдэхүүнийг үнэ төлбөргүй нийлүүлсэн.
- Зах зээлийн үнийн өсөлтөөс шалтгаалахгүйгээр бараа бүтээгдэхүүнийг гэрээний үнээр худалдан авсан гэх мэт.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Мандал сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс-413 дугаар хорих анги нь мэдээлбэл зохих 20 төрлийн 170 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний 1 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 143 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ээлжийн амралтыг биеэр эдлүүлэлгүйгээр 5,951.1 мянган төгрөгийн цалин давхардуулан олгосон 1 зөрчилд албан шаардлага, 8,566.8 мянган төгрөгийн бараа материалын ангилал буруу бүртгэсэн, 142,208.5 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр зөрчлийг давтан гаргасан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	1	5,951.1	1	5,951.1	100.0
Зөвлөмж	2	150,775.3	1	133,344.9	88.4
Нийт дүн	3	156,726.4	2	139,296.0	88.9

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

4.6.1 ШШГЕГ-ын хаалттай хорих 413 дугаар ангийн төсвийн шууд захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн дараах асуудлыг тухайн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцолгүйгээр дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. ШШГЕГ-ын Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газраас өгсөн чиглэлийн дагуу нийт 34,562.0 мянган төгрөгийн үнэтэй уурын зуухны CG 30 маркийн 2 ширхэг бойлерыг БНХАУ-аас худалдаж авсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх *“Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно.”*, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны журмыг сонгоход баримтлах босго үнийн 2 дахь *“Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар Бараа 20.0 сая төгрөг, Ажил 20.0 сая төгрөг”* гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

2. Цалингийн зардлаас тухайн жилийн төсөвт тусгагдаагүй 9,400.2 мянган төгрөгийг төрийн сан дахь “Ахмадын сан”-ийн 100130412507 дугаар дансанд шилжүүлсэн нь Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулан ажиллуулах журам”-ын 1.3 дахь *“Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн 3 хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана.”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.6.2 Дотоод үйлдвэрлэлийн орлогыг дутуу төвлөрүүлсэнтэй холбоотойгоор үүссэн дараах өр төлбөрийг барагдуулсан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй юм. Үүнд:

Монголиан Грийн Фармер ХХК-д дотоод үйлдвэрлэлээр бэлтгэсэн 86,345.8 мянган төгрөгийн хүнсний ногоог борлуулж, 10,000.0 төгрөгийн орлогыг дутуу төвлөрүүлсэн, 70 тн улаан буудайг зах зээлд борлуулаагүйгээс буюу дотоод үйлдвэрлэлийн орлогыг дутуу төвлөрүүлснээс шалтгаалж үйлдвэрлэлтэй холбоотой шатахууны 26,278.3 мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь *“Төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”* гэсэн заалтыг зөрчсөн байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 23,208.6 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 23,208.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

5.1 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар өгсөн төлбөрийн цахим баримтыг үндэслэн ажил гүйлгээг гүйцэтгэж, бүртгэж байх гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй **17,430.4** мянган төгрөгийн худалдан авалтыг гүйцэтгэж, бүртгэсэн буюу зөрчлийг давтан гаргасан байна.

Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “*Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй*”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “*Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм...*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “*Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана*”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэх.

2. Тайлант онд Жавзандамба хутагт төв ТББ-аас нэмэлт санхүүжилтийн дансаар **5,000.0** мянган төгрөгийн хандив авч, зарцуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь “*Хуульд өөрөөр заагаагүй бол зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно:*”, “*25.2.1.эмнэлгийн үйлчилгээ, 25.2.2.бүх шатны боловсролын үйлчилгээ, 25.2.3.соёлын үйлчилгээ*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Хандив, тусламжийн орлого төвлөрүүлж, зарцуулахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Онцгой нөхцөлийн болон цолны нэмэгдлүүдийг зөрүүтэй тооцоолж 4 албан хаагчид **778.2** мянган төгрөг илүү олгосон нь Засгийн газрын 1999 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Зэвсэгт хүчин, бусад цэргийн албан хаагчдын цэргийн цолны цалингийн хувь хэмжээ”-ны “*ахлагч 22 хувь, сургагч ахлагч 26 хувь*”, 2011 оны 189 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хорих байгууллагын албан хаагчдад албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам”-ын 2 дугаар зүйлийн 3 дахь “*Бусад алба 10 хувь*” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэлт: Илүү олгосон цалинг 2023 оны төсвөөс нөхөн суутгах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тээвэр, шатахууны зардалтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Шатахууны зарцуулалтад жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөлгүйгээр өөрсдийн боловсруулсан суудлын автомашины тооцооны хуудас, ажлын даалгавар, шатахуун зарцуулалтын тооцоо гэсэн анхан шатны баримтуудыг хөтөлж байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягыг нөхөх

заавар"-ын 6.4 дэх "Жолоочийн тооцооны хуудас НХМаягт ТМ-4-т "... гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. ... Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана." гэж заасныг зөрчиж байгаа

1.2 **Өгсөн зөвлөмж:** Жолоочийн тооцооны хуудсыг баталсан маягт, аргачлалын дагуу хөтөлж, шатахууны зарцуулалтыг баталгаажуулах.

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 01 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн	
							Тоо	Дүн	Тоо	Дүн			
Дүн													

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүй гээр зөрчлийг давтан гаргасан	1	17,430.4			1	17,430.4							
Хандивын орлого төвлөрүүлж зарцуулсан	1	5,000.0			1	5,000.0							
Цалингийн нэмэгдлийг	1	778.2			1	778.2							

илүү тооцож, олгосон												
Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй	1						1					
Дүн	4	23,208.6			3	23,208.6	1					

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны мэдээллийг мэдээлээгүй	1							1	
Дүн	1							1	
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Дүн									
Нийт дүн	1							1	